



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН УЛСЫН ХОРООНЫ 2021 ОНЫ
САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН
АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: АХГ-2022/05/НА-СТА-ТТЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Аудитын хоёрдугаар газрын захирал, тэргүүлэх аудитор
Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: С.Нацагдорж
Утас: 261628 Цахим хаяг: natsagdorjs@audit.gov.mn
Ахлах аудитор: Д.Болор-Эрдэнэ
Утас: 261628 Цахим хаяг: bolor-erdened@audit.gov.mn
Аудитор: Д.Эрдэнэчимэг
Утас: 260512 Цахим хаяг: erdenechimegda@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын гэрчилгээ	3
2.Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	7
2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	12
3. Аудитын тайлан.....	13
3.1 Ерөнхий зүйл	13
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал АХГ-2022/38/НА-СТА-ТӨА	14
3.4 Материаллаг байдал	14
3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн тодруулга	14
3.5.1 Мөнгөн хөрөнгө	14
3.5.2 Авлага	15
3.5.3 Урьдчилгаа	15
3.5.4 Бараа материал	15
3.5.4 Бусад эргэлтийн хөрөнгө.....	16
3.5.5 Үндсэн хөрөнгө	16
3.5.6 Өр төлбөр	16
3.5.7 Засгийн газрын хувь оролцоо	17
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	17
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	19
3.8 Аудитын гол асуудал	19
3.9 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	19
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	19
3.10 Өмнөх аудитын зөвлөмжийн хэрэгжилт	21
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	21
4. Аудитын илрүүлэлт	21
4.1 Харьяа байгууллагууд	21
4.2 Төсвийн төвлөрүүлэн захирагч	22
4.2.1 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн залруулсан алдаа	22
4.2.2 Албан шаардлага	22
4.2.3.Зөвлөмж.....	22
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	24
5.1 Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа зөрчлийн нэгтгэл.....	24
5.2 Нийцлийн аудитын асуудлаар илэрсэн алдаа зөрчлийн нэгтгэл	25

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
БТСУХ	Биеийн тамир, спортын Улсын хороо
МҮОХ	Монголын үндэсний олимпын хороо
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар
ТӨААТҮГ	Төрийн өмчийн аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ХК	Хувьцаат компани



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН
УЛСЫН ХОРООНЫ ДАРГА
Ц.ШАРАВЖАМЦ ТАНАА

2020.03.25 № 01/720
танай _____-ны № _____-г

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Биеийн тамир, спортын улсын хорооны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Биеийн тамир, спортын улсын хорооны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
АУДИТОРЫН ОРЛОГЧ



Я.САРАНСҮХ

2.Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	93,668,154.4	96,074,136.8
31	Мөнгөн хөрөнгө	2,039,704.6	8,487,921.8
33	Авлага	3,403,731.9	202,963.1
34	Урьдчилгаа	9,489,977.9	4,479,357.1
35	Бараа материал	1,132,835.0	976,116.4
36	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	77,601,904.9	81,927,778.4
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	51,949,236.2	56,199,228.2
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	51,949,236.2	56,199,228.2
392	Биет хөрөнгө	51,104,826.9	55,362,392.3
393	Биет бус хөрөнгө	844,409.3	836,835.9
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	145,617,390.5	152,273,365.1
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	1,838,195.9	9,206,006.8
41	Богино хугацаат өр төлбөр	1,838,195.9	9,206,006.8
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	143,779,194.6	143,067,358.2
51	Засгийн газрын хувь оролцоо	143,779,194.6	143,067,358.2
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	32,881,920.6	33,126,926.7
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,284,813.2	1,284,813.2
51101	Өмч /төрийн/ /ТӨҮГ/	31,597,107.5	31,842,113.6
51200	Хуримтлагдсан үр дүн	82,521,317.8	81,564,475.3
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	28,375,956.2	28,375,956.2
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	145,617,390.5	152,273,365.1

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	56,735,729.6	59,952,289.5
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	15,540,538.0	13,448,806.8
120	Нийтлэг татварын бус орлого	15,540,538.0	13,448,806.8
13	ТУСЛАМЖ САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	41,195,191.6	46,503,482.7
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	20,282,665.2	31,749,795.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	20,282,665.2	31,749,795.2
210	БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	15,961,007.4	28,773,640.5
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,082,336.1	8,015,778.7
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	392,941.9	1,042,332.6
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	231,091.1	188,640.4
2104	Хангамж бараа материалын зардал	88,093.4	321,593.8
2105	Нормативт зардал	49,957.2	782,650.9
2106	Эд хогшил урсгал засварын зардал	45,133.6	243,385.6
2107	Томилолт зочны зардал	7,283.7	25,019.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж	9,305,358.3	15,415,395.6
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,758,811.9	2,738,843.9
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,321,657.8	2,976,154.7
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	-
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	36,453,064.4	28,202,494.3
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	-	1,153.1
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	(11,409,131.8)	29,163,434.4
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(11,409,131.8)	29,162,281.3
V	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	25,043,932.6	(959,787.0)

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2019 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	-	-	-
2	Нягтлах бодох бүртгэлийн	118,735,262.0	-	118,735,262.0
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	118,735,262.0	-	118,735,262.0
4	Тайлант үеийн үр дүн	25,043,932.6	-	25,043,932.6
5	2020 оны 12-р сарын 31-ний	143,779,194.6	-	143,779,194.6
6	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	2,944.6	-	2,944.6
7	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	143,782,139.2	-	143,782,139.2
8	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	245,006.0	-	245,006.0
9	Тайлант үеийн үр дүн	(959,787.0)	-	(959,787.0)
10	2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	143,067,358.2	-	143,067,358.2

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	45,895,464.1	55,553,422.0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	4,700,272.6	8,980,260.7
120	Нийтлэг татварын бус орлого	4,700,272.6	8,980,260.7
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	41,195,191.6	46,573,161.2
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2I)	30,808,923.4	28,217,907.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ	30,808,923.4	28,217,907.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	16,889,309.7	25,241,100.6
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,310,470.7	8,333,380.4
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	421,510.3	1,119,911.2
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	338,598.4	387,052.4
2104	Хангамж, бараа материалын зардал	134,289.8	472,537.1
2105	Нормативт зардал	43,835.0	407,944.6
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,372,131.4	249,929.7
2107	Томилолт, зочны зардал	6,021.5	24,650.2
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,077,765.1	11,304,609.2
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,184,687.5	2,941,085.9
212	ТАТААС	9,598,912.1	-
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,320,701.6	2,976,807.0
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	15,086,540.7	27,335,514.4
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)	60,245.0	-
12	Бусдад олгосон зээл болон урьдчилгааны эргэн төлөлт	60,245.0	-
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	13,062,938.1	20,887,297.2
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	13,062,938.1	20,887,297.2
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(13,002,693.1)	(20,887,297.2)
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	(44,143.0)	-
2200	Бусад эх үүсвэр	3,500.0	8,000.0
8	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	47,643.0	8,000.0
9	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	2,039,704.6	6,448,217.2
10	Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл		2,039,704.6
11	Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл	2,039,704.6	8,487,921.8

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	58,871,409,400.00	57,106,189,529.50	1,765,219,870.50	97.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	26,041,009,400.00	24,985,236,813.50	1,055,772,586.50	95.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	23,507,274,700.00	22,456,689,905.80	1,050,584,794.20	95.5
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	8,036,868,600.00	7,935,905,144.00	100,963,456.00	98.7
210101	Үндсэн цалин	7,416,001,600.00	7,016,129,291.90	399,872,308.10	94.6
210102	Нэмэгдэл	488,515,000.00	755,597,015.30	(267,082,015.30)	154.7
210103	Унаа хоолны хөнгөлөлт	132,352,000.00	135,742,698.80	(3,390,698.80)	102.6
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,087,147,900.00	1,038,272,433.20	48,875,466.80	95.5
210201	Тэтгэврийн даатгал	764,835,600.00	731,656,878.40	33,178,721.60	95.7
210202	Тэтгэмжийн даатгал	80,577,900.00	79,022,724.00	1,555,176.10	98.1
210203	ҮОМШӨ-ний даатгал	64,462,800.00	62,660,199.90	1,802,600.10	97.2
210204	Ажилгүйдлийн даатгал	16,115,700.00	15,033,184.50	1,082,515.50	93.3
210205	Эрүүл мэндийн даатгал	161,155,900.00	149,899,446.50	11,256,453.50	93.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	173,976,800.00	173,976,700.00	100.00	100.0
210301	Гэрэл, цахилгаан	32,684,500.00	40,870,869.90	(8,186,369.90)	125.0
210302	Түлш, халаалт	103,552,100.00	98,400,592.10	5,151,507.90	95.0
210303	Цэвэр, бохир ус	37,740,200.00	34,705,238.00	3,034,962.00	92.0
2104	Хангамж, бараа материалын зардал	305,903,400.00	299,467,733.50	6,435,666.50	97.9
210401	Бичиг хэрэг	42,491,300.00	42,609,715.00	(118,415.00)	100.3
210402	Тээвэр, шатахуун	72,132,800.00	73,551,635.00	(1,418,835.00)	102.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	41,847,100.00	38,098,135.50	3,748,964.50	91.0
210404	Ном, хэвлэл	39,300.00	39,300.00	0.00	100.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	31,244,600.00	24,731,758.00	6,512,842.00	79.2
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	118,148,300.00	120,437,190.00	(2,288,890.00)	101.9
2105	Нормативт зардал	408,913,200.00	407,944,570.00	968,630.00	99.8
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	404,618,200.00	403,894,570.00	723,630.00	99.8
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,295,000.00	4,050,000.00	245,000.00	94.3
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	322,090,400.00	321,214,188.00	876,212.00	99.7
210601	Багаж, техник, хэрэгсэл	180,043,000.00	179,635,180.00	407,820.00	99.8
210602	Тавилга	10,584,000.00	10,582,000.00	2,000.00	100.0

**Биеийн тамир, спортын улсын хорооны 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	4,334,000.00	3,876,300.00	457,700.00	89.4
210604	Урсгал засвар	127,129,400.00	127,120,708.00	8,692.00	100.0
2107	Томилолт, зочны зардал	26,068,300.00	24,650,200.00	1,418,100.00	94.6
210702	Дотоод албан томилолт	26,068,300.00	24,650,200.00	1,418,100.00	94.6
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	11,570,021,900.00	11,464,163,352.20	105,858,547.80	99.1
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	11,528,914,300.00	11,428,027,840.20	100,886,459.80	99.1
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	7,115,500.00	4,660,000.00	2,455,500.00	65.5
210803	Даатгалын үйлчилгээ	1,074,800.00	459,900.00	614,900.00	42.8
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,400,000.00	914,079.00	485,921.00	65.3
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	129,000.00	99,000.00	30,000.00	76.7
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	10,500,000.00	9,721,000.00	779,000.00	92.6
210807	Газрын төлбөр	20,888,300.00	20,281,533.00	606,767.00	97.1
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,576,284,200.00	791,095,585.00	785,188,615.00	50.2
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,533,400,700.00	750,032,209.00	783,368,491.00	48.9
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	42,883,500.00	41,063,376.00	1,820,124.00	95.8
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,533,734,700.00	2,528,546,907.70	5,187,792.30	99.8
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	68,708,300.00	68,535,848.70	172,451.30	99.7
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	68,708,300.00	68,535,848.70	172,451.30	99.7
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,465,026,400.00	2,460,011,059.00	5,015,341.00	99.8
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	2,084,180,000.00	2,084,180,000.00	0.00	100.0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	318,825,800.00	314,714,362.00	4,111,438.00	98.7
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	62,020,600.00	61,116,697.00	903,903.00	98.5
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	32,830,400,000.00	32,120,952,716.00	709,447,284.00	97.8
220001	Барилга байгууламж	32,248,400,000.00	31,549,818,349.00	698,581,651.00	97.8
221001	Их засвар	247,000,000.00	243,825,167.00	3,174,833.00	98.7
222001	Тоног төхөөрөмж	335,000,000.00	327,309,200.00	7,690,800.00	97.7
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	58,871,409,400.00	57,106,189,529.50	1,754,315,574.50	97.0
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	58,416,009,400.00	56,968,419,846.50	1,447,589,553.50	97.5
310001	Улсын төсвөөс санхүүжих	58,416,009,400.00	56,968,419,846.50	1,447,589,553.50	97.5
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	455,400,000.00	137,769,683.00	306,726,021.00	30.3
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	449,400,000.00	121,541,576.90	327,858,423.10	27.0
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	6,000,000.00	16,228,106.10	(10,228,106.1)	270.5

Биеийн тамир, спортын улсын хорооны 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		2,039,704,630.90		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		8,487,921,810.10		
	БАЙГУУЛЛАГЫН ТОО	33	33	-	100.0
	Төсвийн байгууллага	33	33	-	100.0
	АЖИЛЛАГСАДЫН ТОО	726	726	-	100.0
	Удирдах ажилтан	41	41	-	100.0
	Гүйцэтгэх ажилтан	370	370	-	100.0
	Үйлчлэх ажилтан	289	289	-	100.0
	Гэрээт ажилтан	26	26	-	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		569,308,873.21
2	УРСГАЛ ЗАРДАЛ		569,308,873.21
3	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		349,020,857.00
4	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		30,837,000.00
5	Нэмэгдэл		30,837,000.00
6	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		4,060,205.00
7	Тэтгэврийн даатгал		4,060,205.00
8	Хангамж, бараа материалын зардал		77,800.00
9	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		77,800.00
10	Эд хогшил, урсгал засварын зардал		29,078,770.00
11	Багаж, техник, хэрэгсэл		10,273,000.00
12	Урсгал засвар		18,805,770.00
13	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		5,719,400.00
14	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		5,719,400.00
15	Бараа үйлчилгээний бусад зардал		279,247,682.00
16	Бараа үйлчилгээний бусад зардал		279,247,682.00
17	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		220,288,016.21
18	Бусад урсгал шилжүүлэг		130,711,781.00
19	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал		128,250,000.00
20	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		2,461,781.00
21	Олгосон санхүүжилт, шилжүүлэг		89,576,235.21
22	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг		89,576,235.21
23	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		569,308,873.21
24	Нэмэлт санхүүжилтийн орлого		569,308,873.21
25	ЗГНХ, ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		450,307,000.00
26	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		119,001,873.21
27	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		-
28	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		-

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Биеийн тамир, спортын улсын хорооны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад хөрөнгийн тооллогыг чанартай гүйцэтгэж, хадгалалт, хамгаалалтад бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах, гэрээгээр олгосон санхүүжилтийн гүйцэтгэлд хяналт тавьж, төсвийг зориулалтын дагуу зарцуулах, НБББББ-ийг боловсруулж, мөрдөж ажиллах талаар өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Үндэсний аудитын газрын Аудитын хоёрдугаар газрын ахлах аудитор Д.Болор-Эрдэнэ, аудитор Д.Эрдэнэчимэг 2022 оны 3 дугаар сарын 05-ны өдрөөс 2022 оны 3 дугаар сарын 25-ны өдрийн хооронд гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер С.Нацагдорж, Аудитын хоёрдугаар газрын захирал, Тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг, Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогч Я.Сарансүх нар хэрэгжүүлсэн.

Биеийн тамир, спортын улсын хорооны 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2022 оны 3 дугаар сарын 04-ний өдрийн 1/143 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Биеийн тамир, спортын улсын хорооны үйл ажиллагааны зорилго нь хөгжлийн чиг хандлага, хүн амын хэрэгцээнд нийцүүлэн биеийн тамир, спортын салбарын бодлогын үр нөлөөг дээшлүүлэн олон талт, тэгш, хүртээмжтэй, чанартай үйлчилгээг хэрэгжүүлэх замаар бие бялдрын боловсролтой, ёс суртахууны төлөвшилтэй, эрүүл чийрэг иргэнийг төлөвшүүлэхэд оршино. Биеийн тамир, спортын улсын хороо нь үйл ажиллагааны стратегийн зорилтын хүрээнд дараах чиг үүргийг гүйцэтгэж байна. Үүнд:

- Иргэн бүрд нийтийн биеийн тамир, спортын үйлчилгээ үзүүлэх төр, хувийн хэвшлийн түншлэлд суурилсан нээлттэй, уян хатан тогтолцоог бүрдүүлэх;
- Биеийн тамир, спортын үйлчилгээ чанар, гүйцэтгэлд тулгуурласан санхүүжилт, даатгалын тогтолцоо боловсронгуй болох;
- Биеийн тамир, спортын салбарт цахим үйлчилгээ нэвтэрч, үндэсний нэгдсэн мэдээллийн сан бүрдүүлэх;
- Биеийн тамир, спортын салбарын хүний нөөцийн хөгжил, чадавхжуулалт, дэмжлэгийг нэмэгдүүлэх

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Засгийн газрын 2020 оны “Агентлаг байгуулах тухай” 47 дугаар тогтоол;
- Сангийн сайдын 2021 оны “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”-ыг шинэчлэн батлах тухай 190 дүгээр тушаал;
- Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоол;
- Засгийн газрын 2021 оны “Босго үнэ шинэчлэн батлах тухай” 124 дүгээр тогтоол;

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил хэрэгжүүлэхэд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны “Агентлаг байгуулах тухай” 47 дугаар тогтоолоор тохируулагч агентлаг байгуулагдсанаар Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэстэй болж, 5 орон тоотой ажилласан байна.

Тус байгууллага нь Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг батлаагүй байгаа нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцэхгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд тусалцаа авах шаардлагатай гэж үзлээ.

3.3 САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Санхүүгийн нэгтгэсэн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитын зорилго оршино.

Биеийн тамир, спортын улсын хорооны 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил, гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлсэн байна.

3.4 МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардал 52,897.5 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 528.9 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж үзэхэд санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайланд хөрөнгө оруулалтын барьцаа хөрөнгийг өглөг дансанд бүртгэснээс тайланд залруулга хийсэн тул материаллаг байдлыг нийт зардлын 60,913.2 сая төгрөгийн 1.0 хувь буюу 609.1 сая төгрөгөөр шинэчлэн тогтоосон.

3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн тодруулга

Биеийн тамир, спортын улсын хорооны 2021 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 6,656.0 сая төгрөгөөр буюу 4.6 хувиар нэмэгдсэн байна. Өмнөх оны үзүүлэлтээс мөнгөн хөрөнгө, авлага, урьдчилгаа, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөрийн дансуудад материаллаг өөрчлөлт гарсан байна.

3.5.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 8,487.9 сая төгрөг болж 6,448.2 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Хүснэгт 1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

			/мянган төгрөг/
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Касст байгаа бэлэн мөнгө	-	-	-
Банканд байгаа бэлэн мөнгө	2,039,704.6	8,487,921.8	6,448,217.2
Дүн	2,039,704.6	2,039,704.6	6,448,217.2

Эх сурвалж: Биеийн тамир, спортын улсын хорооны 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 6,488.2 сая төгрөгөөр өссөн нь Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 397 дугаар тогтоолын дагуу 2021 онд хийх бүтээн

байгуулалтын хүрээнд барилга, байгууламж барихаар баталсан хөрөнгө оруулалтын төсвийг төрийн сангийн барьцаа хөрөнгийн дансанд байршуулсантай холбоотой байна.

Аудитын илрүүлэлт

-Буянт-Ухаа спортын ордон ТӨААТҮГ нь Засгийн газрын нөөц сангаас спортын ордны барилгын их засварын ажилд зориулж олгосон 257.2 сая төгрөгийн санхүүжилтийг тайлант үеийн үйл ажиллагааны зардалд зарцуулж, төсвийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан;
-Булган хангал спорт бэлтгэлийн төв ТӨААТҮГ нь шатахууны тооцоог жолоочийн замын хуудасгүй, анхан шатны баримт бүрдэл дутуу баримтаар 5.7 сая төгрөгийн гүйлгээ хийсэн;
-Булган хангал спорт бэлтгэлийн төв ТӨААТҮГ нь бэлэн мөнгө хүссэн өргөдөлд даргын зөвшөөрөлгүй, анхан шатны баримтын бүрдэл дутуу баримтаар 6.6 сая төгрөгийг зарцуулсан.

3.5.2 Авлага

Авлага дансны үлдэгдэл 202.9 сая төгрөг болж, 3,200.8 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 2. Авлагын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөг/ Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагсадтай холбогдсон авлага	1,097.5	11,930.6	10,833.1
Татаас, санхүүжилтийн авлага	-	96.0	96.0
Байгууллагаас авах авлага	3,402,634.4	190,936.5	(3,211,697.9)
Дүн	3,403,731.9	202,963.1	3,200,768.8

Эх сурвалж: Биеийн тамир, спортын улсын хорооны 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Байгууллагаас авах авлага дансны үлдэгдэл 3,211.7 сая төгрөгөөр буурсан нь 2020 онд “Токио-2020” олимпын наадмын бэлтгэл ажлыг хангахтай холбоотойгоор үндэсний шигшээ багийн холбоодтой байгуулсан гэрээний хүрээнд дотоодын бэлтгэл цугларалтад олгосон санхүүжилтийн гүйцэтгэл нөлөөлсөн байна.

3.5.3 Урьдчилгаа

Урьдчилгаа дансны үлдэгдэл 4,479.4 сая төгрөг болж, 5,010.6 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 3. Урьдчилгаа дансны үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөг/ Өсөлт (+), Бууралт (-)
Урьдчилж гарсан зардал	9,489,977.9	4,479,357.1	5,010,620.8
Дүн	9,489,977.9	4,479,357.1	5,010,620.8

Эх сурвалж: Биеийн тамир, спортын улсын хорооны 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Урьдчилгаа дансны үлдэгдэл 5,010.6 сая төгрөгөөр буурсан нь Улаанбаатар спорт менежмент ХК-д олгосон Олон Улсын залуучуудын ногоон наадмын бэлтгэл ажлын зардалд олгосон төслийн ажлын гүйцэтгэлийг 4,928.0 сая төгрөгөөр тайлант хугацаанд зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэсэн байна.

Аудитын илрүүлэлт

- Буянт-Ухаа спортын ордон ТӨААТҮГ-ын авлага дансны үлдэгдэлд 16 хувь хүн, хуулийн этгээдийн 39.4 сая төгрөгийн авлага эзэн холбогдогч нь тодорхой бус, тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.

3.5.4 Бараа материал

Бараа материалын дансны үлдэгдэл 976.1 сая төгрөг болж, 156.7 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 4. Бараа материалын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөг/ Өсөлт (+), Бууралт (-)
Тусгай зориулалтын материал	284,076.0	431,842.2	147,766.2
Эм боох	641,337.5	218,305.2	(423,032.3)
Бэлэн бүтээгдэхүүн	1,403.1	531.0	(872.1)
Бичиг хэргийн материал	28,224.1	44,187.3	15,963.2

АХГ-2022/05/НА-СТА-ТТЗ

Аж ахуйн материал	123,265.2	105,265.2	(18,000.0)
Сэлбэг хэрэгсэл	-	1,707.5	1,707.5
Түлш, шатах тослох материал	3,974.0	4,456.8	482.8
Барилгын засварын материал	3,588.6	6,764.1	3,175.5
Бусад хангамжийн материал	46,527.0	117,928.1	71,401.1
Дүн	1,132,835.0	976,116.4	(156,718.6)

Эх сурвалж: Биеийн тамир, спортын улсын хорооны 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материалын үлдэгдэл 156.7 сая төгрөгөөр буурсан нь Токио, Бээжингийн олимпын арга хэмжээнд үндэсний шигшээ багийн тамирчдыг оролцуулах бэлтгэлийн хувцас, хэрэглэл, материалыг бэлтгэж, зарцуулснаас шалтгаалжээ.

Бараа материалын үлдэгдлийн 66.6 хувь буюу 650,147.4 сая төгрөг нь үндэсний шигшээ багийн тамирчдын хувцас, хэрэглэл, Спортын анагаах ухааны эрдэм шинжилгээний төвийн эм боох материалын үлдэгдэл байна.

3.5.4 Бусад эргэлтийн хөрөнгө

Бусад эргэлтийн хөрөнгө 4,325.8 сая төгрөгөөр нэмэгдсэн нь Биеийн тамир, спортын улсын хорооны харьяа байгууллагуудын хэмжээнд 2021 онд хөрөнгө оруулалтын санхүүжилт 33,400.0 сая төгрөгөөр нэмэгдсэн, ТӨБЗГ-ын 2021 оны 487 дугаар тогтоолоор 28,900.0 сая төгрөгийн хөрөнгийг Орон нутгийн өмчийн газарт шилжүүлсэн нь нөлөөлсөн байна.

3.5.5 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 56,199.2 сая төгрөг болж, 4,250.0 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 5. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Биет хөрөнгө			
Барилга, байгууламж, орон сууц	49,550,911.5	48,938,995.1	(611,916.4)
Авто-тээврийн хэрэгсэл	54,098.6	38,648.7	(15,449.9)
Машин тоног төхөөрөмж(компьютер)	783,995.3	793,869.2	9,873.9
Тавилга, аж ахуйн эд хогшил	159,731.3	251,149.1	91,417.8
Бусад үндсэн хөрөнгө	398,324.3	731,793.0	333,468.7
Дуусаагүй барилга байгууламж	157,765.9	4,607,937.2	4,450,171.3
Биет бус хөрөнгө			
Программ хангамж	43,105.1	34,211.7	(8,893.4)
Бусад биет бус хөрөнгө	801,657.1	802,624.2	967.1
Дүн	51,949,236.2	56,199,228.2	4,249,992.0

Эх сурвалж: Биеийн тамир, спортын улсын хорооны 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 4,250.0 сая төгрөгөөр өссөн нь Улаанбаатар спорт менежмент ХК-д олгосон Олон Улсын залуучуудын ногоон наадмын бэлтгэл ажлын гүйцэтгэлийг баталгаажуулан 4,607.9 сая төгрөгийг дуусаагүй барилга дансанд бүртгэсэн, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны А/70 дугаар тушаалаар баталсан хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний дагуу 2020 онд худалдан авах ажиллагааг зохион байгуулсан боловч Ковид-19 цар тахлын улмаас хойшлогдож, 2021 онд 550.7 сая төгрөгийн компьютер, тоног төхөөрөмж худалдан авсан болон ТӨБЗГ-ын 2021 оны 86, 691, 719 дүгээр тогтоолоор нийт 1,218.6 сая төгрөгийн хөрөнгийг, Буянт ухаа спортын ордон ТӨААТҮГ нь ТӨБЗГ-ын 2021 оны 518 дугаар тогтоолын дагуу 116.5 сая төгрөгийн хөрөнгийг акталж, данснаас хассан зэрэг нь тус тус нөлөөлсөн байна.

3.5.6 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн дансны үлдэгдэл 9,206.0 сая төгрөг болж, 7,367.8 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 6. Нийт өр төлбөрийн үлдэгдэл

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагсадтай холбоотой өглөг	81,311.3	108,186.7	26,875.4
Байгууллагад төлөх өглөг	1,081,783.4	8,721,138.2	7,639,354.8
Татварын өглөг	523,508.7	195,745.4	(327,763.3)
Нийгмийн даатгалын шимтгэлийн өглөг	99,642.5	118,736.5	19,094.0
Бусад урьдчилж орсон орлого	51,950.0	62,200.0	10,250.0
Дүн	1,838,195.9	9,206,006.8	7,367,810.9

Эх сурвалж: Биеийн тамир, спортын улсын хорооны 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Богино хугацаат өр төлбөрийн үлдэгдэл 7,367.8 сая төгрөгөөр өссөн нь Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 397 дугаар тогтоолын дагуу хөрөнгө оруулалтын батлагдсан зардлыг барилга, бүтээн байгуулалтын ажил зогссонтой холбоотой дараа жилд зарцуулахаар төрийн сангийн дансанд түр байршуулан өглөг дансанд бүртгэсэн, харьяа төрийн өмчит үйлдвэрийн газрууд нь Ковид-19 цар тахлын улмаас үйл ажиллагаа нь удааширсантай холбоотойгоор НДШ-ийн өглөг 118.7 сая төгрөгөөр, ХХОАТ-ын өглөг 195.7 сая төгрөгөөр нэмэгдсэн нь тус тус нөлөөлсөн байна.

Аудитын илрүүлэлт:

-Буян-Ухаа ТӨААТҮГ нь албан татвар суутган төлөгчөөс худалдан авсан бараа, ажил үйлчилгээний төлбөрийн баримтыг тухай бүр цаас болон цахим хэлбэрээр аваагүйгээс санхүүгийн тайлан дахь НӨАТ-ын өглөг, татварын НӨАТ-ын тайлангийн үлдэгдлээс 24.3 сая төгрөгөөр илүү тайлагнасан.

3.5.7 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 143,067.4 сая төгрөг болж, 711.8 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 7. Засгийн газрын хувь оролцоо

/ мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Засгийн газрын оруулсан капитал	32,881,920.6	33,126,926.7	245,006.1
Хуримтлагдсан үр дүн	82,524,262.3	81,564,475.3	(959,787.0)
Өмнөх үеийн үр дүн	57,477,385.1	82,524,262.3	25,046,877.2
Тайлант үеийн үр дүн	25,043,932.5	(959,787.1)	(24,084,145.4)
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	28,375,956.2	28,375,956.2	-
Дүн	143,782,139.1	143,067,358.2	(714,780.9)

Эх сурвалж: Биеийн тамир, спортын улсын хорооны 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Хуримтлагдсан үр дүн 81,564.5 сая төгрөг болж, 959.8 сая төгрөгөөр буурсан нь тайлант онд 959.8 сая төгрөгөөр үр дүн буурсанаас шалтгаалжээ. Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл өссөн нь Техник спортын төв ТӨААТҮГ нь тайлант хугацаанд нь өнгөрсөн оны аудитын зөвлөмжийн дагуу 245.0 сая төгрөгийн өртөгтэй газар бүртгэсэнтэй холбоотой байна.

Өмнөх үеийн үр дүн 25,046.0 сая төгрөгөөр нэмэгдсэн нь Орон нутагт эрх шилжсэн хөрөнгө оруулалтын 25,203.4 сая төгрөгийг үр дүнгийн тайланд орлого хүлээн зөвшөөрч бусад эргэлтийн хөрөнгөнд бүртгэсэн, мөн тайлант үеийн үр дүн нь ТӨБЗГ-ийн 487 дугаар тогтоолын дагуу 28,915.1 сая төгрөгийн 14 объектийг харьяа орон нутгийн өмчид шилжүүлснээр тайлант оны үр дүн буурахад тус тус нөлөөлсөн байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Төсвийн төвлөрүүлэн захирагч нь урсгал үйл ажиллагааны 2021 оны төсвийн төслийн нийт зарлага ба зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 68,917.3 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсөв захирагчид хүргүүлсэн байна.

Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хуулиар төсөв захирагчийн нийт зарлага ба зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 58,871.4 сая төгрөгөөр буюу 10,045.9 сая төгрөгөөр бууруулан баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 14 хөтөлбөрт зориулан 58,871.4 сая төгрөгийн төсөв батлагдаж, 58,416.0 сая төгрөгийг улсын төсвөөс, 454.4 сая төгрөгийг үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс урсгал зардлын санхүүжилтэд 24,757.3 сая төгрөг, хөрөнгийн санхүүжилтэд 32,120.9 сая төгрөг, нийт 56,878.2 сая төгрөгийн санхүүжилт олгож 57,106.1 сая төгрөгийг зарцуулж, зарцуулагдаагүй үлдэгдэл 227.9 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлжээ.

Хүснэгт 8. Үйл ажиллагааны орлого

/мянган төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Үндсэн үйл ажиллагааны орлого	449,400.0	133,901.8	(315,498.2)	29.8
Туслах үйл ажиллагааны орлого	5,000.0	14,800.0	9,800.0	296.0
Нийт дүн	454,400.0	148,701.8	305,698.2	32.7

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 57,106.2 сая төгрөг буюу 97.0 хувьтай байгаа нь Ковид-19 цар тахлын нөлөөгөөр цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал 48.8 сая төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж зардлыг 105.0 сая төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардлыг 785.1 сая төгрөгөөр хэмнэж, тэвчиж болох зардлыг хойшлуулах, төлөвлөгөөт арга хэмжээг цуцалснаас өөрийн орлогын төлөвлөгөө тасарсан зэрэг нь нөлөөлсөн байна.

Тайлант хугацаанд Допингийн эсрэг үйл ажиллагааг дэмжих /82109/ хөтөлбөр, арга хэмжээнд тусгасан 520.0 сая төгрөгийг зарцуулаагүй байна.

Хүснэгт-9. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөг/

Д/Д	Хөтөлбөр, арга хэмжээний		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
	Код	Нэр				
1	71701	Биеийн тамир, спорт	58,871,409.4	57,106,189.6	1,245,219.8	97.0
1.1	80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	12,726,491.6	12,201,997.8	524,493.8	95.9
1.2	80219	Харуул, хамгаалалтын зардал	35,500.0	35,500.0	-	100.0
1.3	80226	Байр ашиглалтын үйлчилгээ	210,514.2	210,514.2	-	100.0
1.4	80509	Гадаадын болон ОУБ-ын гишүүнчлэлийн хураамж	68,708.3	68,708.3	-	100.0
1.5	80704	Ахмад дайчин алдар цолтой ахмад настанд үзүүлэх хөнгөлөлт тусламж	10,000.0	10,000.0	-	100.0
1.6	80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	30,198.8	18,919.9	11,278.8	62.7
1.7	82101	Улсын шигшээ багийн үйл ажиллагааг дэмжих	9,428,515.4	9,428,515.4	-	100.0
1.8	82102	Олон улсын тэмцээн уралдаанд оролцох	557,625.8	557,625.8	-	100.0
1.9	82103	Олон улсын тэмцээн уралдааны шагнал	501,030.0	501,030.0	-	100.0
1.10	82104	Дотоодын тэмцээн уралдаан зохион байгуулах	119,710.4	119,710.4	-	100.0
1.11	82105	Олимп ДАШТ-с медаль авсан тамирчдын урамшуулах	1,573,150.0	1,573,150.0	-	100.0
1.12	82106	Нийтийн биеийн тамир	259,564.9	259,564.9	-	100.0
1.13	82109	Допингийн эсрэг үйл ажиллагааг дэмжих	520,00.0	-	520,000.0	-
1.14	80918	Бусад	32,830,400.0	32,120,952.7	709,447.3	97.8

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансанд Засгийн газрын нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан 450.3 сая төгрөг, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон 119.0 сая төгрөг нийт 569.3 сая төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Соёлын сайдын 2021 оны А/50 дугаар “Иргэдийн наадам зохион байгуулах тухай” тушаалын дагуу 315.0 сая төгрөгийн санхүүжилт олгож, 256.4 сая төгрөгийг аймаг, дүүргийн Биеийн тамир, спортын газруудад хуваарилан наадамд зарцуулж, гүйцэтгэлийн тайланг тус яаманд хүргүүлсэн байна. Мөн алдар цолтон ахмад настанд төрөөс нэмэгдэл, хөнгөлөлт олгох тухай хуулийн дагуу БТСУХ-ны даргын 2021 оны А/18 дугаар тушаалаар 128.2 сая төгрөг, түрээсийн өглөгт 19.6 сая төгрөг, урсгал засварын зардалд 77,8 сая төгрөгийг тус тус зарцуулж, зарцуулагдаагүй үлдэгдэл 87.3 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Засгийн газрын 2021 оны 143 дугаар тогтоолоор Буянт-Ухаа спорт цогцолбор, Спорт бэлтгэлийн төвд 766.7 сая төгрөгийг олгож, өр, төлбөрийг барагдуулан нэмэлт санхүүжилтийн тайланд тохируулга бичилт хийсэн байна.

Нэмэлт төсвийн санхүүжилтийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Биеийн тамир, спортын улсын хорооны 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгасан 12 зорилт бүхий 49 арга хэмжээг Хяналт-шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын хэлтсээс үнэлж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийн дундаж үнэлгээ 86.2 хувьтай, өмнөх оны үнэлгээнээс 5.0 хувиар өссөн байна.

3.8 Аудитын гол асуудал

Тус байгууллага нь Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиггүй байгаа нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцэхгүй байна.

Татварын багц хууль болон нягтлан бодох бүртгэлийн маягт хөтлөх аргачлал, Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журамтай нийцүүлэн байгууллагын онцлогт тохирсон Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг мөрдөж ажиллах шаардлагатай байна.

3.9 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Харьяа байгууллагуудад илэрсэн нийцлийн аудитын асуудлаар нийт 26.8 сая төгрөгийн 24 зөрчил илрүүлснээс Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах, зөрчлийг арилгах 2 албан шаардлага өгсөн байна.

Аудитын илрүүлэлт

- Буянт-Ухаа спортын ордон ТӨААТҮГ шилэн дансны мэдээллийн санд 160 мэдээлэл оруулахаас хугацаандаа оруулсан 2 хугацаа хоцроосон 105, баталгаажуулаагүй 41, мэдээлэл оруулаагүй 12 мэдээлэл байна;

- Булган хангал спорт бэлтгэлийн төв шилэн дансны мэдээллийн санд 171 мэдээлэл оруулахаас, 35 мэдээлэл хугацаа хоцроож, 1 мэдээллийг байршуулаагүй байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

1. Биеийн тамир, спортын улсын хороо нь “Олон улсын залуучуудын ногоон наадмын зохион байгуулалтын зарим үйл ажиллагааг улсын төсвөөс санхүүжүүлэх” 2020 оны 1/69 дүгээр гэрээг Улаанбаатар спорт менежмент ХК-тай байгуулж, 2020 онд нийт 9,598.9 сая төгрөгийн санхүүжилт олгосон.

Илрүүлэлт: Аудитаар санхүүжилтийн тооцоо, ажлын гүйцэтгэл, үлдэгдлийг Улаанбаатар спорт менежмент ХК-ийн тайлан, санхүүжилтийн гүйцэтгэлтэй тулгахад тамирчдын хувцас, хэрэглэлийн зарцуулагдаагүй үлдэгдэл 35.3 сая төгрөгийн зардлыг улсын төсөвт буцаан татан төвлөрүүлээгүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.7 “Энэ хуулийн 43 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд төсвийн жил дуусахад төсвийн захирагчийн төсөв зарцуулах эрх нь дуусгавар болох бөгөөд төсвийн захирагчийн төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүүжилтийн зарцуулагдаагүй 35.3 сая төгрөгийн үлдэгдлийг улсын төсөвт буцаан татан төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоох

2. Биеийн тамир, спортын улсын хорооны дотоод аудитын гүйцэтгэсэн ажилтай танилцахад Хяналт-шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын хэлтэс дараах зөрчлийг илрүүлсэн байна. Үүнд:

- Монголын допингийн эсрэг байгууллага нь улсын төсвөөс 2020 онд олгосон 455.0 сая төгрөгийн санхүүжилтийн гүйцэтгэлийг БТСУХ-ны 2020 оны төсвийн гүйцэтгэлийн тайланд нэгтгүүлээгүй;
- Улсын төсвөөс 2020 онд олгосон 455.0 сая төгрөгийн санхүүжилтийн зарцуулаагүй үлдэгдэл 147.9 сая төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлээгүй;
- Допингийн хяналтын хөтөлбөр зардлын 71.0 сая төгрөгийг анхан шатны баримтын бүрдэл дутуу баримтаар гүйлгээ хийсэн;
- Мөн компьютер, тоног төхөөрөмж, урсгал засварын зардалд 60.5 сая төгрөгийг зарцуулж, төсвийг зориулалт бусаар зарцуулсан зөрчлийг илрүүлсэн боловч шалгалтын дүнг баталгаажуулж, холбогдох арга хэмжээг авч ажиллаагүй байна.

Илрүүлэлт: Тус хороо нь 2021 оны төсөвт батлагдсан Допингийн эсрэг үйл ажиллагааг дэмжих хөтөлбөр арга хэмжээний санхүүжилтийн гүйцэтгэлийг хангаж ажиллаагүй, “Допингийн эсрэг үндэсний дүрэм”-ийг боловсруулаагүй, Хяналт-шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн санхүүгийн хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийг баталгаажуулан холбогдох арга хэмжээг авч ажиллаагүй нь Төсвийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.11 “төсөв, санхүүгийн дотоод аудит, хяналт шалгалтыг зохион байгуулж, удирдлагаар хангах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, 19 дүгээр зүйлийн 19.1 “Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн дотоод хяналтын бодлого, удирдлага, зохион байгуулалтыг аж ахуйн нэгж, байгууллагын эрх бүхий этгээд тодорхойлно” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: “Допингийн эсрэг үндэсний дүрэм”-ийг боловсруулж батлуулах, дотоод аудитын хяналт, шалгалтын дүнг баталгаажуулж, холбогдох арга хэмжээг авч ажиллан, хэрэгжилтийг ирүүлэх албан шаардлага хүргүүлэх

Харьяа байгууллагуудад илэрсэн нийцлийн аудитын асуудлаар нийт 26.8 сая төгрөгийн 24 зөрчил илрүүлснээс Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд зөрчлийг арилгах 2 албан шаардлага өгсөн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль холбогдох заалтуудтай, төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг буцаан төвлөрүүлээгүй нь Төсвийн тухай хуулийн холбогдох заалттай тус тус нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх аудитын зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар төсвийн төвлөрүүлэн захирагчид алдаа, зөрчлийг арилгах 73.3 сая төгрөгийн 4 албан шаардлага хүргүүлэн, биелэлт 95.0 хувьтай, 257.3 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 6 зөвлөмж хүргүүлэн, биелэлт 73.3 хувьтай байна.

Хүснэгт 10. Өмнөх оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар тогтоосон акт, өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	4	72,755.2	4	72,755.2	-	-	95.0
Зөвлөмж	6	257,300.0	5	193,900.0	1		73.3
Дүн	10	330,055.2	3	266,655.2	1	-	84.1

Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжөөс Техник спортын төв ТӨААТҮГ нь газрын төлбөрт төлөх 63.4 сая төгрөгийн өглөгийг Ковид -19 цар тахлын улмаас үйл ажиллагаа явуулж орлого төвлөрөөгүйн улмаас төлөөгүй байна.

3.11 ДАРААГИЙН АУДИТААР АНХААРАХ АСУУДАЛ

Биеийн тамир, спортын улсын хорооны санхүүгийн нэгтгэсэн тайланд Засгийн газрын 2021 оны 388 дугаар тогтоолын дагуу аймаг, нийслэл, дүүргийн Биеийн тамир, спортын байгууллагуудын санхүүгийн тайланг 2022 оны 2 дугаар улирлаас эхлэн нэгтгэх болсонтой холбогдуулан дараагийн аудитаар анхаарал хандуулах шаардлагатай гэж үзлээ.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 1,553.0 сая төгрөгийн 23 алдаа, зөрчил илэрснээс, 1,179.0 сая төгрөгийн 5 алдааг залруулж, 35.6 сая төгрөгийн 2 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 302.5 сая төгрөгийн 8 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж, 35.9 сая төгрөгийн алдаа зөрчилд 8 зөвлөмж өгсөн.

Залруулагдаагүй нийт алдаа, зөрчил 374.0 сая төгрөг нь тогтоосон ерөнхий материаллаг байдал 609.1 сая төгрөгөөс бага тул “Зөрчилгүй” дүгнэлт өгсөн.

4.1 Харьяа байгууллагууд

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 5 төсвийн байгууллагын санхүүгийн тайлан нэгтгэснээс 2 байгууллагад дүгнэлт гаргаж, 3 байгууллага түүвэрт хамруулсан.

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд “Зөрчилгүй” 1, “Хязгаарлалттай” 1 дүгнэлт өгсөн байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 1,058.2 сая төгрөгийн 10 алдаа, зөрчил илрүүлснээс 1,022.9 сая төгрөгийн 3 алдааг аудитын явцад залруулж, 35.3 сая төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт тогтоож, зөрчлийг арилгах 3 албан шаардлага хүргүүлж, зөрчлийг давтан гаргахгүй байх 3 зөвлөмжийг хүргүүлсэн байна.

4.2 Төсвийн төвлөрүүлэн захирагч

4.2.1 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн залруулсан алдаа

- Үр дүнгийн тайланд өмнөх оны үр дүнгийн нийт орлого, зарлагыг 13.0 сая төгрөгөөр дутуу, мөнгөн гүйлгээний тайлангийн нийт орлого, зарлагыг 30.4 сая төгрөгөөр дутуу тайлагнасан байна.
- Өмчийн өөрчлөлтийн тайланд үндсэн хөрөнгийн үнэлгээний өсөлт, бууралтыг 2.9 сая төгрөгөөр зөрүүтэй, өмчид гарсан өөрчлөлтийн дүнг 645.9 сая төгрөгөөр илүү илэрхийлсэн.
- Техник спортын төв ТӨААТҮГ-ын мөнгөн гүйлгээний тайлангийн мөнгөн зарлагын эдийн засгийн ангиллыг 330.5 сая төгрөгөөр ангилал хооронд зөрүүтэй илэрхийлсэн байна.

4.2.2 Албан шаардлага

1.1 Илрүүлэлт: Харьяа байгууллагуудад хийсэн аудитаар залруулагдаагүй нийт 338.7 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 0.3 сая төгрөгийн 1 акт тогтоож, 302.5 сая төгрөгийн 7 албан шаардлага, 35.9 сая төгрөгийн 8 зөвлөмж өгсөн байгаа нь Төсвийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.11 "төсөв, санхүүгийн дотоод аудит, хяналт шалгалтыг зохион байгуулж, удирдлагаар хангах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 19 дүгээр зүйлийн 19.1 "Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн дотоод хяналтын бодлого, удирдлага, зохион байгуулалтыг аж ахуйн нэгж, байгууллагын эрх бүхий этгээд тодорхойлно" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Харьяа байгууллагуудын санхүүгийн нэгтгэсэн тайлангаар илэрсэн алдаа зөрчилд эрсдэлийн үнэлгээ хийж, эрсдэлд суурилсан төлөвлөгөө боловсруулж, хэрэгжилтийг хангаж ажиллах, албан шаардлага хүргүүлэх

1.2 Илрүүлэлт: Улаанбаатар спорт менежмент ХК, Биеийн тамир, спортын улсын хороо Спорт цогцолборын барилгын ажлын зардлыг дуусаагүй барилга дансанд давхар бүртгэсэн асуудлыг холбогдох газарт хандан шийдвэрлүүлээгүй, улсын төсвөөс олгосон санхүүжилтийн гүйцэтгэлд хяналт тавьж ажиллаагүй нь Төсвийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2 "Төсвийн захирагчийн төсвийн дараах зарцуулагдаагүй үлдэгдлийг төсвийн хэмнэлтэд тооцохгүй бөгөөд тухайн үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлнэ", 45.2.2 "төлөвлөсөн төсөл, арга хэмжээ хэрэгжээгүйн улмаас, эсхүл тоо хэмжээ нь буурснаас бий болсон үлдэгдэл", 11 дүгээр зүйлийн 11.1.11 "төсөв, санхүүгийн дотоод аудит, хяналт шалгалтыг зохион байгуулж, удирдлагаар хангах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 19 дүгээр зүйлийн 19.1 "Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн дотоод хяналтын бодлого, удирдлага, зохион байгуулалтыг аж ахуйн нэгж, байгууллагын эрх бүхий этгээд тодорхойлно" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Дуусаагүй барилга дансанд Спорт цогцолборын барилгын ажлын зардлыг давхар бүртгэсэн зөрчлийг арилгаж, батлагдсан төсвийг зориулалтын дагуу хэмнэлттэй, үр ашигтай байхаар төлөвлөж зарцуулах, зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэх

4.2.3.Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1.1 Илрүүлэлт: Санхүүгийн тайланд бүртгэлтэй 12,591 төрлийн 341.8 сая төгрөгийн үнэ бүхий бараа материал 13 төрлийн шигшээ багийн холбоодод бүртгэлтэй боловч тооллогод хамрагдаагүй, эд хариуцагчийн карт хөтлөөгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан

бодогч нар хариуцна.12.2 “Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ, 12.2.1 жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө” 20 дугаар зүйлийн 20.2.3 "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэж заасантай нийцэхгүй байна.

1.2 Өгсөн зөвлөмж: Бараа материалын тооллогыг хугацаанд нь чанартай гүйцэтгэж, эд хариуцагчийн карт хөтлөх

2.1 Илрүүлэлт: Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, цаашид ашиглах боломжтой 186 ширхэг 694.8 сая төгрөгийн хөрөнгө бүртгэлтэй байгаа нь ТӨБЗГ-ын 2019 оны 271 дүгээр тогтоолын 7 дугаар зүйлийн 7.1-д "Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ" гэж заасантай нийцэхгүй байна.

2.2 Өгсөн зөвлөмж: Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн цаашид ашиглах боломжтой хөрөнгийн судалгаа гаргаж ТӨБЗГ-т хандан шийдвэрлүүлэн, тогтоол шийдвэрийн дагуу хөрөнгөд дахин үнэлгээ хийх, бүртгэл тайланд тусгах

3.1 Илрүүлэлт: Биеийн тамир, спортын улсын хороо нь НБББББ, нэгтгэсэн тайлан гаргах салбарын онцлогт тохирсон заавар баталж мөрдөөгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тогтоолоор баталсан "Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам", 2021 оны “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”-ыг шинэчлэн батлах тухай 190 дүгээр тушаалтай тус тус нийцэхгүй байна.

3.2 Өгсөн зөвлөмж: Нэгтгэсэн тайлан гаргах салбарын онцлогт тохирсон заавар баталж, холбогдох стандартын дагуу НБББББ-ийг боловсруулан, мөрдөж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Үндэсний аудитын газарт 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

5.1 Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа зөрчлийн нэгтгэл																				
д/д	Байгууллагын нэр	Аудитын код	Аудитын санал дүгнэлт						Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс									
			Үүнээс								Залруулга		Акт		Албан шаардлага		Хариуцлага тооцох		Зөвлөмж	
			Бүгд	Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс тагалаах	Түүвэрт хамруулсан	тоо	Дүн	тоо	Дүн	тоо	Дүн	тоо	дүн	тоо	дүн	Тоо	дүн
1	Биеийн тамир, спортын улсын хороо	АХГ-2022/05/НА-СТА-ТТЗ	1	1	-	-	-	-	10	1,058,255.7	3	1,022,934.9	1	35,320.8	3	-	-	-	3	-
2	Буянт-Ухаа спортын ордон ТӨААТҮГ	АХГ-2022/40/НА-СТА-ТӨА	1		1	-	-	-	10	482,104.5	2	156,094.0	-	-	4	296,746.6	-	-	4	29,263.9
3	Булган хангал спорт бэлтгэлийн төв ТӨҮГ	БУА-2022/6/НА-СТА-ТӨҮГ	1	1	-	-	-	-	3	12,688.7	-	-	1	305.7	1	5,762.0	-	-	1	6,621.0
4	Биеийн тамир, спортын улсын хороо аппарат	-	1	-	-	-	-	1	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
5	Техник, спортын төв	АХГ-2022/38/НА-СТА-ТӨА	1	-	-	-	-	1	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
6	Спортын анагаах ухаан эрдэм, шинжилгээний төв	АХГ-2022/150/НА-СТА-ТШЗ	1	-	-	-	-	1	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
ДҮН			6	2	1	-	-	3	23	1,553,048.9	5	1,179,028.9	2	35,626.5	8	302,508.6	-	-	8	35,884.9

5.2 Нийцлийн аудитын асуудлаар илэрсэн алдаа зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөг/

д/д	Байгууллагын нэр	Аудитын код	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс										
					Залруулга		Акт		Албан шаардлага		Хариуцлага тооцох		Зөвлөмж		
			тоо	Дүн	тоо	Дүн	тоо	Дүн	тоо	дүн	тоо	дүн	Тоо	дүн	
1	Буянт-Ухаа спортын ордон ТӨААТҮГ	АХГ-2022/40/НА-СТА-ТӨА	1	-	-	-	-	-	-	1	24,092.0	-	-	-	-
2	Булган хангал спорт бэлтгэлийн төв	БУА-2022/6/НА-СТА-ТӨҮГ	1	-	-	-	-	-	-	1	2,721.0	-	-	-	-
			2							2	26,813.0				



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2022 оны 03 дугаар сарын 25 № 157/А0160067

Улаанбаатар хот

АХГ-2022/05)НА-СТА-ТТЗ
Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Биеийн тамир, спортын улсын хорооны 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Спорт цогцолборын барилгын ажлын зарцуулагдаагүй үлдэгдэл 35,320,500.00 төгрөгийг улсын төсөвт буцаан татан төвлөрүүлээгүй байна.


Энэ нь Төсвийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2 "Төсвийн захирагчийн төсвийн дараах зарцуулагдаагүй үлдэгдлийг төсвийн хэмнэлтэд тооцохгүй бөгөөд тухайн үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлнэ", 45.2.2 "төлөвлөсөн төсөл, арга хэмжээ хэрэгжээгүйн улмаас, эсхүл тоо хэмжээ нь буурснаас бий болсон үлдэгдэл" гэж тус тус заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журмын 4.2.3-д заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Зарцуулагдаагүй үлдэгдэл 35,320,500.00 төгрөгийг /гучин таван сая гурван зуун хорин мянга таван зуун/ төгрөгийг Үндэсний аудитын газрын Төрийн сан банкна дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Биеийн тамир, спортын улсын хорооны дарга Ц.Шаравжамц, Санхүү бүртгэл, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Э.Адьяасүрэн, Улаанбаатар спорт менежмент ХК-ийн гүйцэтгэх захирал Б.Тамир, ерөнхий нягтлан бодогч Д.Оюун-Эрдэнэ нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
Д.БОЛОР-ЭРДЭНЭ
Д.ЭРДЭНЭЧИМЭГ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

\\0.10.10.20\Bichig_Kherig\Akt\2022\0325 Auditin 2 Газар-89.Docx

0001000270



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 25 № 749/A 0160067

Улаанбаатар хот

АХГ-2022/05/НА-СТА-ТТЗ
Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Биеийн тамир, спортын улсын хорооны 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тус хороо нь 2021 оны төсөвт батлагдсан Допингийн эсрэг үйл ажиллагааг дэмжих хөтөлбөр арга хэмжээний санхүүжилтийн гүйцэтгэлийг хангаж ажиллаагүй, "Допингийн эсрэг үндэсний дүрэм"-ийг боловсруулаагүй, Хяналт-шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн санхүүгийн хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийг баталгаажуулан холбогдох арга хэмжээг авч ажиллаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.11 "төсөв, санхүүгийн дотоод аудит, хяналт шалгалтыг зохион байгуулж, удирдлагаар хангах", 16 дугаар зүйлийн 16.5.5 "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 19 дүгээр зүйлийн 19.1 "Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн дотоод хяналтын бослого, удирдлага, зохион байгуулалтыг аж ахуйн нэгж, байгууллагын эрх бүхий этгээд тодорхойлно", 20 дугаар зүйлийн 20.2.5 "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. "Допингийн эсрэг үндэсний дүрэм"-ийг боловсруулж батлуулах, дотоод аудитын санхүүгийн хяналт шалгалтын дүнг баталгаажуулж, холбогдох арга хэмжээг авч ажиллах, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Биеийн тамир, спортын улсын хорооны дарга Ц.Шаравжамц, Санхүү бүртгэл, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Э.Адьяасүрэн нарт даалгав.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

Ц.НАРАНЧИМЭГ
Д.БОЛОР-ЭРДЭНЭ
Д.ЭРДЭНЭЧИМЭГ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230



\\10.10.10\20\Bichig_Khereg\Alban Shaardlaga\2022\0325 Auditin 2 Gazar-403.Docx

9006109
9019120396

0001081932



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 25 № 750/А0160067

Улаанбаатар хот

АХГ-2022/05/НА-СТБ-ТТЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Биеийн тамир, спортын улсын хорооны 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Улаанбаатар спорт менежмент ХК, Биеийн тамир, спортын улсын хороо нь Спорт цогцолборын барилгын ажлын батлагдсан төсвийн хэмнэлтийг зориулалт бусаар зарцуулсан, зардлыг дуусаагүй барилга дансанд давхар бүртгэсэн асуудлыг холбогдох газарт хандан шийдвэрлүүлээгүй, улсын төсвөөс олгосон санхүүжилтийн гүйцэтгэлд хяналт тавьж ажиллаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 11 дүгээр зүйлийн 11.1.11 "төсөв, санхүүгийн дотоод аудит, хяналт шалгалтыг зохион байгуулж, удирдлагаар хангах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 19 дүгээр зүйлийн 19.1 "Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн дотоод хяналтын бодлого, удирдлага, зохион байгуулалтыг аж ахуйн нэгж, байгууллагын эрх бүхий этгээд тодорхойлно", 20 дугаар зүйлийн 20.2.5 "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Дуусаагүй барилга дансанд Спорт цогцолборын барилгын ажлын зардлыг давхар бүртгэсэн зөрчлийг арилгаж, батлагдсан төсвийг зориулалтын дагуу хэмнэлттэй, үр ашигтай байхаар төлөвлөж зарцуулах, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Биеийн тамир, спортын улсын хорооны дарга Ц.Шаравжамц, Санхүү бүртгэл, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Э.Адьяасүрэн, Улаанбаатар спорт менежмент ХК-ийн гүйцэтгэх захирал Б.Тамир, ерөнхий нягтлан бодогч Д.Оюун-Эрдэнэ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
Д.БОЛОР-ЭРДЭНЭ
Д.ЭРДЭНЭЧИМЭГ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-261230

9006109
9019120396

\\10.10.10.20\Bichig_Khereg\Alban_Shaardlaga\2022\0325_Auditin_2_Gazar-405.Docx

0001001030



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 25 № 751/А0160067

Улаанбаатар хот

АХГ-2022/05/НА-СТА-113

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Биеийн тамир, спортын улсын хорооны 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Харьяа байгууллагуудад хийсэн аудитаар залруулагдаагүй нийт 338,698,897.00 төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 305,720.00 төгрөгийн 1 акт тогтоож, 302,508,462.00 төгрөгийн 7 албан шаардлага, 35,884,715.00 төгрөгийн 8 зөвлөмж өгсөн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.11 "төсөв, санхүүгийн дотоод аудит, хяналт шалгалтыг зохион байгуулж, удирдлагаар хангах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээн", 19 дүгээр зүйлийн 19.1 "Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн дотоод хяналтын бодлого, удирдлага, зохион байгуулалтыг аж ахуйн нэгж, байгууллагын эрх бүхий этгээд тодорхойлно" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Харьяа байгууллагуудын санхүүгийн нэгтгэсэн тайлангаар илэрсэн алдаа зөрчилд эрсдэлийн үнэлгээ хийж, эрсдэлд суурилсан төлөвлөгөө боловсруулж, хэрэгжилтийг хангаж ажиллах, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Биеийн тамир, спортын улсын хорооны дарга Ц.Шаравжамц, Санхүү бүртгэл, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Э.Адъяасүрэн нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
Д.БОЛОР-ЭРДЭНЭ
Д.ЭРДЭНЭЧИМЭГ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

\\10.10.10.20\Bichig_Khereg\Alban Shaardlaga\2022\0325 Auditin 2 Gazar-404.Docx

0001081028

